



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын
2023 онд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд
гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн тухай тайлан

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/230 дугаар тушаалаар батлагдсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам” болон бусад холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдлөг болгон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, зохих шийдвэр гаргуулан, хуулийн хугацаанд хариуг өгч ажиллаж байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 511 өргөдөл, гомдол ирүүлснээс 425 өргөдлийг хуулийн хугацаанд, 86 өргөдлийг хугацаа хоцорч шийдвэрлэсэн байна. Хугацаа хоцорсон шийдвэрлэлт 16,8% байна.

Хүснэгт 1. 2023 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт /хувиар/
			Шийдвэрлэж хариу өгсөн тоо	Бусад байгууллагад шилжүүлсэн тоо	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн тоо		
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	511	511	-	86	-	100%

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг нийт 5 сувгаар хүлээн авч, бүртгэл хөтлөлтийг хийн, шийдвэрлүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлж байна.

1. Иргэдээс – 346 /67,7%/;
2. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв – 165 /32,3%/;
3. Албаны утас – 0;
4. Шуудан – 0;
5. Цахим хуудас, олон нийтийн сүлжээ – 0 тус тус хүлээн авсан.

Хүснэгт 2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт /хэлбэрээр/

Д/д	Газар, хэлтсийн нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Хүлээн авсан байдал					
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	1111 төвөөр	Бусад
1	Захиргаа, удирдлагын газар	290	282				8	
2	Чанарын хяналтын газар	68	19				49	
3	Эм хангамжийн газар	75	3				72	
4	Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар	9	2				7	
5	Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар	25	7				18	
6	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн газар	8	7				1	
7	Эмийн бүртгэлийн хэлтэс	34	26				8	
8	Эм үйлдвэрлэлийн хэлтэс	1	-				1	
9	Эм шинжлэх лаборатори	1	-				1	
	Нийт	511	346				165	

Хүснэгт 3. Өргөдөл, гомдлын агуулга

Д/д	Утга	Өргөдөл, гомдлын нийт тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1	Эм, тарианы хүртээмж, тасалдал, эмийн үнийн өсөлтийн тухай	75	14,7%
2	Эмийн сан, эмийн чанар, эмийн бүтээгдэхүүнд хяналт, шалгалт хийлгэх тухай	68	13,4%
3	Монгол улсын эмийн бүртгэлийн тухай	34	6,6%
4	Бусад	334	65,3%
	Нийт	511	100%

Хүснэгт 4. Өргөдөл, гомдлын төрөл

Д/д	Төрөл	Бодит тоо	Нийт өргөдөлд эзлэх хувь
1	Гомдол	123	24%
2	Санал	30	5,9%
3	Хүсэлт	353	69%
4	Мэдээлэл	5	1,1%
	Нийт	511	100%